



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**“ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН
ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ,
ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ”
ТАЛААР ДҮГНЭЛТ ГАРГАХ АУДИТ**

АУДИТЫН КОД: ХОА-2023/12-20-НА-НА

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408

Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 70432545

Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn

Аудитор: Ц.Бадрал

Утас: 70432545

Цахим хаяг: Badralts@audit.gov.mn

Ховд хот

2023 оны 11 сар



АГУУЛГА

БҮЛЭГ 1. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН ТАТВАР, ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ 425.6 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА	4
Нийт орлогын 45.1 хувийг татварын орлогоор, 1.8 хувийг татварын бус орлогоор бүрдүүлэхээр төлөвлөжээ.....	4
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогыг нэмэгдүүлэх боломж байна	5
Цалин, хөдөлмөрийн хөлсний нэмэгдэлтэй холбогдуулан цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварыг хүлээгдэж буй гүйцэтгэлээс 4,964.7 сая төгрөгөөр буюу 34.4 хувиар нэмэгдүүлэн тооцжээ	6
Газрын төлбөрийн орлогыг 22.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна	6
Хог хаягдлын хураамжийн орлогыг 158.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх нөөц байна.....	7
Татварын бус орлогыг 244.7 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн, түрээсийн гэрээ байгуулахгүйгээр зарим төрийн өмчийг ашиглуулж байна.....	8
БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТУУДЫГ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД ИРҮҮЛЭЭГҮЙГЭЭС ТӨЛӨВЛӨСӨН АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦЭЖ БАЙГАА ЭСЭХЭД ДҮГНЭЛТ ӨГӨХ БОЛОМЖГҮЙ БАЙНА	9
Урсгал зардлын өсөлтөд төрийн албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдэл, эрүүл мэндийн салбарын тогтмол зардлыг орон нутгаас хариуцан төлөх болсон нь гол нөлөөлөл үзүүлсэн байна	9
Хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний зардлын задаргааг холбогдох хууль, журамд нийцүүлэн боловсруулсныг нотлох боломжгүй байна.....	11
БҮЛЭГ 3. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН УРСГАЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТИЙН ҮР АШИГ, ХҮРЭХ ҮР ДҮНГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ЗАРДЛЫГ АНГИЛАН ТӨЛӨВЛӨСӨН Ч ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНГ ТООЦОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА	12
Төсвийн төсөлд 27 хөтөлбөрийн хүрээнд 33 арга хэмжээг төлөвлөжээ.....	12
ДҮГНЭЛТ:	14
ЗӨВЛӨМЖ:.....	14
ХАВСРАЛТУУД	16-26

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС

Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт



ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
УМС	Удирдлага мэдээллийн систем
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
БӨЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн

ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Шугам сүлжээний газрын төлбөрийн орлого	16
Хавсралт 2	Газрын төлбөрийн тооцоо	17
Хавсралт 3	Хог хаягдлын төлбөр, хураамжийн орлогын судалгаа	18-23
Хавсралт 4	Төсөвт байгууллагуудын түрээсийн орлого нэмэгдүүлэх судалгаа	24
Хавсралт 5	Орон нутгийн өмчийг түрээслүүлснээс оруулах түрээсийн орлогын талаарх судалгаа	25
Хавсралт 6	Авто зам ашигласны төлбөр төлөгч тээврийн хэрэгслийн судалгаа	26

ХҮСНЭГТ БОЛОН ГРАФИКИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орон нутгийн төсвийн суурь орлого 2023-2024 он	4
Хүснэгт 2	Аймгийн ИТХ-аар орон нутгийн татварын орлого бүрдүүлэхтэй холбоотой гаргасан шийдвэрүүд	5
Хүснэгт 3	Сумдын сургуулийн дотуур байрны илүү төлсөн халаалтын зардал	10
График 1	Төсвийн орлого	4
График 2	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын сүүлийн 3 жилийн төлөвлөгөө, гүйцэтгэл	6
График 3	Төсвийн зарлага	9
График 4	Орон тооны мэдээлэл	10

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн дагуу Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн гүйцэтгэлээ.



Аудитын зорилго	“Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх” гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэнэ. Энэ зорилготой холбоотой дараах асуудлын хүрээнд аудитыг төлөвлөж гүйцэтгэв. Үүнд: ➤ Төсвийн орлого нэмэгдүүлэх нөөц боломж байгаа эсэх, ➤ Төсвийн төсөлд зарлага бууруулах боломжийг бүрэн тусгасан эсэх, ➤ Төсвийн төсөлд төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломжийг бүрэн тусгасан эсэх,
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4001-д нийцүүлсэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим”-ын стандарт арга зүйд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар “Төрийн аудит байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/71 дугаар “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглав.
Аудитын хамарсан хүрээ	“Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх” гүйцэтгэлийн аудитаар аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан холбогдох бодлогын зорилтын хэрэгжилт, эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт, хяналт, санхүүгийн үйл ажиллагаа, үр ашигт судалгаа хийх, нэгтгэсэн дүн шинжилгээ, харьцуулалт хийх, тулган баталгаажуулах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлэн ажиллаж хөтөлбөр, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитад аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтэс, Татварын хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон холбогдох бусад байгууллагын аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ. Аймгийн Засаг дарга нь төсвийн саналыг холбогдох шаардлагад нийцүүлэн нэгтгэн боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх үүрэгтэй. Засаг даргаас аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн 2024 оны төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.
Хүндрэл бэрхшээл	Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д “Төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах ... мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах” гэж заасны дагуу Ховд аймгийн ТЭЗ-ын 2024 оны төсвийн төслийн тооцоололтой холбоотой нотлох баримтыг ирүүлэхийг Аймгийн Засаг даргад 2023 оны 9 дүгээр сарын 18-ний өдрийн 234 дугаартай албан бичгүүдээр мэдэгдсэн боловч ирүүлээгүй, ХБТХОХ-ээс 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын жагсаалт, холбогдох баримтууд ирүүлсэнгүй.




БҮЛЭГ 1. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН ТАТВАР, ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ 425.6 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА

Нийт орлогын 45.1 хувийг татварын орлогоор, 1.8 хувийг татварын бус орлогоор бүрдүүлэхээр төлөвлөжээ

1.1.1 Аймгийн 2024 оны төсвийн орлогыг нийт дүнгээрээ 91,194.1 сая төгрөгөөр төлөвлөсний 44.9 хувь буюу 41,253.4 сая төгрөгийг татварын болон татварын бус орлогоор, 1.3 хувь 512.9 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 16.3 хувь буюу 15,014.7 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээр, 30.5 хувь буюу 28,053.0 сая төгрөгийг ОНХС-ийн орлогын шилжүүлгээр, 6.9 хувь буюу 6,360.0 сая төгрөгийг бусад сангаас бүрдүүлэхээр тус тус төлөвлөжээ.

График №1



Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны төсвийн суурь орлогыг 40,082.7 сая төгрөгөөр төлөвлөн Сангийн яаманд хүргүүлж, Сангийн яамнаас 37,495.0 сая төгрөгөөр хянан баталсан байна

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3¹ -т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар тусгасны дагуу орон нутгийн 2024 оны төсвийн орлогыг 37,495.0 сая төгрөгөөр төлөвлөсний 96 хувийг буюу 36,021.5

сая төгрөг нь татварын, 4 хувийг буюу 1,473.5 сая төгрөгийг татварын бус орлогоос бүрдүүлэхээр тооцсон нь 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 5,795.4 сая төгрөгөөр буюу 18.3 хувиар нэмэгдүүлжээ.

2024 оны татварын орлого нэмэгдэхэд хувь хүний орлогын албан татварыг 56.1 хувиар, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг өмнөх оноос 4,586.0 сая төгрөгөөр буюу 54.5 хувиар, бусад татварыг 60.3 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн, малд ноогдуулах татварыг өмнөх онд 919.4 сая төгрөгөөр баталсан, 2024 онд төлөвлөөгүй, хөрөнгийн албан татварыг 754.1 сая төгрөгөөр буюу 31.4 хувиар, татварын бус орлогыг 468.8 сая төгрөгөөр буюу 22.5 хувиар тус тус бууруулан төлөвлөсөн зэргээс шалтгаалсан байна.

Хүснэгт -№1

Орон нутгийн төсвийн суурь орлого 2023-2024 он

ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны	2024 оны		
	Төлөвлөгөө	Сангийн яаманд хянуулсан	Аймгийн ИТХ-д оруулсан	хувь
НИЙТ ОРЛОГО	30,074.10	37,495.00	41,253.40	37.17
ТАТВАРЫН ОРЛОГО	27,891.00	36,021.50	39,539.10	41.76
Хувь хүний орлогын албан татвар	13,988.10	18,906.80	21,832.50	56.08
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	-880.8	-969.3	-969.3	10.04
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	8,414.00	13,000.00	13,000.00	54.5

¹ жилийн төсвийн хязгаарт багтаасан байх;



Хөрөнгийн албан татвар	2,403.10	1,649.00	1,649.00	-31.38
Бусад татвар	3,966.60	3,435.00	4,026.90	1.52
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,083.10	1,473.50	1,614.30	-22.51
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	100	100	100	-

Татварын суурь орлогыг тооцоходоо Сангийн яамны төсвийн төсөл бэлтгэх удирдамж, өмнөх оны болон тайлан оны хагас жилийн татварын систем дэх тоо мэдээлэлд үндэслэн Сангийн яамнаас ирүүлсэн орлогын маягтын дагуу 17 сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч, БОАЖГ-аас ирүүлсэн тоо мэдээллийг нэгтгэн төлөвлөсөн байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогыг нэмэгдүүлэх боломж байна

1.1.2 Аймгийн ИТХ-аас Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Ашигт малтмалын тухай, Газрын төлбөрийн тухай зэрэг хуулиудад заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгийн, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн, байгалийн ургамал, рашаан, замын байгууламж ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц, газрын төлбөртэй холбоотой тогтоол шийдвэрүүдийг гаргасан байна.

Хүснэгт №2 Аймгийн ИТХ-аар орон нутгийн татварын орлого бүрдүүлэхтэй холбоотой гаргасан шийдвэрүүд			
д/д	Татварын төрөл	Баталсан огноо	Дугаар
1	Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувь хэмжээ	2012.12.18	02//03
2	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл"-ийн жилийн албан татварын хэмжээ	2010.12.28	6//06
3	Бичил худалдаа, ажил үйлчилгээ эрхлэгч хувь хүний үйл ажиллагааны орлогоос хураах татварын хувь хэмжээ	2019.12.03	10//10
4	Байгалийн ургамал ашигласны төлбөр, рашаан ашигласны төлбөр	2012.10.26	10//04
5	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	2015.12.02	9//03
6	Аймгийн газрын үнэлгээний бүсчлэл, газрын төлбөрийн итгэлцүүрийг тогтоох тухай	2021.12.04	5//08
7	Аймаг, сум дахь төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ	2022.12.03	10//08
8	Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөр	2022.06.10	7//04
9	Нэгж тариф батлах тухай / Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тариф/	2023.03.30	11//07

Үүнээс үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1²-д 2021 оны 07 дугаар сард нэмэлт өөрчлөлт орж хувь хэмжээг нэмэгдүүлсэн ч аймгийн ИТХ-аар шинэчлээгүй байна.

Буянт сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Эко цементийн үйлдвэр 2023 онд ашиглалтад орж үйл ажиллагаа хэвийн явагдаж байхад үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг барилга байгууламж бүрээр гаргаагүйгээс албан татварын ногдуулаагүй байна.

Татварын орлоготой холбоотой аймгийн ИТХ-аас баталсан ТЕЗ-ийн 2023 оны сумдын татварын орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлийг хянахад үл хөдлөх хөрөнгийн албан татвар, бууны албан татвар, газрын төлбөр, байгалийн ургамал ашигласны төлбөр, малд ногдуулах татвар, ан амьтан агнах зөвшөөрлийн хураамжийг орон нутгийн онцлог, бүрдүүлэх

² Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан 0.6-2.0 хувиар тооцож ногдуулна.



татварын нөөц судалгаанд үндэслэхгүйгээр зарим нэр төрлийн татварын орлогыг тэнцүү хуваарилан төсөвлөснөөс сумдын зарим нэр төрлийн орлого тасрах төлөвтэй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлд нэн ховор ургамал, ховор ургамал, элбэг ургамал ашигласны төлбөр ногдуулахаар заасан, байгалийн ямар төрлийн ургамалд экологи эдийн засгийн үнэлгээ хийлгэсэн эсэх нь тодорхойгүй, БОАЖЯ-наас зөвшөөрөл олгогдоогүй байхад байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогыг ТЕЗ-ийн 2024 оны төсөвт 33.0 сая төгрөгөөр төлөвлөж, сумдад 0.5-7.0 сая төгрөгөөр хуваарилан бүрдүүлэхээр төлөвлөжээ.


Цалин, хөдөлмөрийн хөлсний нэмэгдэлтэй холбогдуулан цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварыг хүлээгдэж буй гүйцэтгэлээс 4,964.7 сая төгрөгөөр буюу 34.4 хувиар нэмэгдүүлэн тооцжээ

1.1.3 Монгол улсын 2024 оны төсөвт орлогын доод хэмжээг Ховд аймагт цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татварыг 16,453.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр сангийн яамаар хянуулан, аймгийн ИТХ-д 19,378.8 сая төгрөгийн татварын орлого бүрдүүлэхээр хүргүүлсэн байна.

Төрийн байгууллагуудын тоон мэдээлэл судалгаанд үндэслэн 2024 оны 4 дүгээр сараас цалин хөлсийг 10 хувиар мөн орон нутгийн нэмэгдлийг төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, улс төрийн албан хаагчдын цалинг аймгийн төвд 20 хувь, сумдад ажиллаж байгаа албан хаагчдын цалинг 40 хувиар тус тус нэмэгдүүлэхээр тооцсон байна.

Төрийн байгууллагуудын тоон мэдээлэл судалгаанд үндэслэн, ирэх оны 4 дүгээр сараас цалин хөлсийг 10 хувиар нэмэгдүүлнэ гэж тооцож төлөвлөсөн байна.

График №2. Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын сүүлийн 3 жилийн төлөвлөгөө, гүйцэтгэл



Графикаас үзэхэд 2021 онд 1,447.2, 2022 онд 1,820.0 сая, 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2,458.2 сая төгрөгөөр давуулан биелэх үзүүлэлттэй байна.

Газрын төлбөрийн орлогыг 22.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна

1.1.4 Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны төсвийн төсөлд газрын төлбөрийн орлогыг 799.0 сая төгрөгөөр Сангийн яамаар хянуулан төлөвлөсөн нь Засгийн газраас тогтоосон газрын суурь үнэлгээ, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон итгэлцүүр, эзэмшил, ашиглалтад байгаа газрын мэдээлэл болон ирэх онд хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний нөлөөлөл, 2023 оны газрын төлбөрийн ногдол, ГХБХБГ-аас гаргасан судалгаа зэрэгт үндэслэн газрын төлбөрийн орлогыг 614.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт, аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04-ны



өдрийн 5/08 дугаар тогтоолын хавсралтын дагуу аймгийн нутаг дэвсгэрт олон улсын болон орон нутгийн чанартай, аж ахуйн нэгж байгууллагын дотоодын зам, мэдээлэл холбооны шугам сүлжээ, эрчим хүчний шугам сүлжээ, дулаан цэвэр бохир усны шугам сүлжээний газрын төлбөрийн итгэлцүүрээр ногдуулаагүйгээс газрын төлбөрийн орлогоос 22.7 сая төгрөг төсөвт төвлөрүүлэх боломжтой байна. (Хавсралт №1)

- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас газрын төлбөрийн 2023 оны ногдуулалт, суурь судалгаанд үндэслэн тооцоход 591.9 сая төгрөг ногдуулах боломжтойг аудитын явцад нэмэгдүүлэн аймгийн ИТХ-д хүргүүлэх төсвийн төсөлд тусгасан. (Хавсралт №2)

Хог хаягдлын хураамжийн орлогыг 158.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх нөөц байна

1.1.5 Хог хаягдлын хураамжийн орлогыг 2024 оны төсвийн төсөлд 51.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн нь өмнөх оны төлөвлөгөөнөөс 27.0 сая, ХБГ-ээс 28.4 сая төгрөгөөр тус тус бууруулан төлөвлөсөн байна. Хог хаягдлын хураамжийн тухай хуулийн 9.2.2³-д заасны дагуу сумдын ИТХ-ын тогтоолоор хог хаягдлын хураамжийн орлогыг айл, өрх, төсөвт байгууллага, аж ахуйн нэгж болон бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага бүрээр сар, жилээр тооцон орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан.

Сүүлийн жилүүдэд хот, аймгийн төвүүдэд төвлөрөл эрс нэмэгдсэн, иргэдийн хэрэглээ өсөхийн хэрээр байгаль орчинд их хэмжээний сөрөг нөлөөлөл үүсэж агаар, хөрсний бохирдол нэмэгдэж, хог хаягдал их хэмжээгээр хуримтлагдаж байгаа ч хог хаягдлын хураамжийн орлогыг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

Сумдын ИТХ-аар баталж холбогдох дээд шатны байгууллагаар баталгаажуулсан тогтоолоор сумдын татварын орлогын төлөвлөгөөнд хог хаягдлын хураамжийг бодитой тоо мэдээлэл үндэслээгүй, батлагдсан тарифтай уялдуулан төлөвлөөгүйгээс 158.2 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломж байна. (Хавсралт №3)

Айл өрхөд ногдох хог хаягдлын хураамжийг Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7-д “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг эрчим хүч, хэрэглээний цэвэр, бохир ус, дулаан, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөртэй хамтатган хураах замаар төвлөрүүлж болно” гэж зааснаар төвлөрүүлэхэд 28.4 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломжтой.

Булган сумын ТТЗ-ийн 2024 оны хог хаягдлын хураамжийн орлогыг 5.0 сая төгрөгөөр төлөвлөж орлогыг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлээгүй, Минжит Булган Хот тохижуулах газрын дансанд төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8-д “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.8.12-д “хог хаягдлын үйлчилгээний хураамж”, Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8-д “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд сумдын ИТХ-ын тогтоолоор баталж, эрх зүйн мэдээллийн санд оруулсан тогтоолууд, тоон мэдээлэл судалгаанд үндэслэн ногдуулалтыг бүрэн хийж татварын орлогын бүрдүүлэлтэд хяналт тавих бүх шатны байгууллагуудын ажлын хариуцлагыг дээшлүүлэн ажиллах шаардлагатай байна.

³ энэ хуулийн 8.7.1-д заасан аргачлалын дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох



Татварын бус орлогыг 244.7 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн, түрээсийн гэрээ байгуулахгүйгээр зарим төрийн өмчийг ашиглуулж байна

1.1.6 Хөрөнгө борлуулсны болон түрээсийн орлогыг 100.0 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 121.5 сая төгрөгөөр, бусад орлогыг 504.0 сая төгрөгөөр тус тус тооцон төлөвлөжээ. Үүнд:

- ТӨБЗГ-ын 2020 оны 49 тоот тогтоолоор “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар”-ын 1⁴-д зааснаар орон нутгийн өмч хөрөнгийг бусад түрээслүүж, түрээсийн гэрээ байгуулснаас 29.7 сая төгрөгийн орлого (Хавсралт4 №),
- Аймгийн ЗДТГ-т бүртгэлтэй орон сууцыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 127 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад “албаны орон сууц эзэмшүүлэх журам”-ын 3.1⁵ дэх хэсэгт зааснаас бусад хувь хүмүүст ашиглуулснаас ТӨБЗГ-ын 49 тоот тогтоолын жишиг үнээр тооцоход 14.3 сая төгрөгийн орлого (Хавсралт №5),
- Сумдын ЗДТГ-ын данс бүртгэлтэй уурын зуухны барилгыг дулаан хангагч байгууллагад ашиглуулан Чандмань сум түрээсийн гэрээ байгуулсан ч орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, Эрдэнэбүрэн, Дуут, Дөргөн, Мянгад сумдууд гэрээ байгуулаагүй,
- Булган сумын 7,829.9 сая төгрөгийн өртөгтэй инженерийн нэгдсэн шугам сүлжээг Булган Түшиг ХХК-д ашиглуулсан ч түрээсийн гэрээ байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2⁶, ТӨБЗГ-ын 49 дүгээр тогтоолын хавсралтыг зөрчсөн, түрээслүүлэн орлого бүрдүүлэх боломжтой,.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 204 тоот тогтоолын дагуу 2023 онд 18 тээврийн хэрэгсэлд дуудлага худалдаа зохион байгуулагдаж 112.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн, 2024 онд 13 тээврийн хэрэгслийг худалдан борлуулснаас 100.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломжтой,
- Аймгийн ИТХ-ын 2022 оны 7/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтад “Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн хэмжээ”-г тээврийн хэрэгсэл эзэмшигчдээс авахаар тусгасны дагуу аймаг дахь Авто тээврийн төвөөс 2023 оны тээврийн хэрэгслийн техникийн үзлэгийн тоо мэдээнд үндэслэн тооцоход замын хураамжийн орлогоос 2024 онд 200.7 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломж байна. (Хавсралт №6)

Төсөвт байгууллагуудын өөрийн үйл ажиллагааны орлогыг 2023 онд 71.8 сая төгрөгөөр баталсныг 2024 онд 32.3 сая төгрөгөөр бууруулан 39.5 сая төгрөгөөр төлөвлөн Сангийн яаманд хянуулсан нь төсвийн төслийг боловсруулахдаа бодитой тоо мэдээлэл судалгаанд үндэслэн төлөвлөдөггүй, орон нутгийн байгууллагуудаас ирүүлсэн тоо мэдээлэл бодит бус зэргээс шалтгаалж байна. Аудитын явцад 121.5 сая төгрөгөөр буюу 82.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

⁴ Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх төлбөрийн доод хязгаарыг түрээслэгчийн эрхэл буй үйл ажиллагааны ангилал, салбарын чиглэл зэргийг харгалзан дараах байдлаар тогтооно

⁵ Орон сууцыг дараах байдлаар албан тушаалаар нь байгууллагуудад хуваарилан эзэмшүүлнэ

⁶ Засгийн газраас тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ.



БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТУУДЫГ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД ИРҮҮЛЭЭГҮЙГЭЭС ТӨЛӨВЛӨСӨН АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦЭЖ БАЙГАА ЭСЭХЭД ДҮГНЭЛТ ӨГӨХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.


Урсгал зардлын өсөлтөд төрийн албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдэл, эрүүл мэндийн салбарын тогтмол зардлыг орон нутгаас хариуцан төлөх болсон нь гол нөлөөлөл үзүүлсэн байна

2.1.1 Аймгийн 2024 оны төсвийн зарлагыг 91,194.0 сая төгрөг байхаар тооцсон бөгөөд хөрөнгө оруулалтад 6,000.0 сая, ОНХС-гаар 28,053.0 сая, урсгал зардалд 52,596.9 сая, хөрөнгийн зардалд 4,544.1 сая төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

График №3

Аймгийн төсвийн суурь зарлагыг өмнөх онтой харьцуулахад 30 хувиар өссөн, 2024 оны төсвийн төслийн суурь зарлагыг Сангийн яамнаас 52,509.7 сая төгрөгөөр хянасныг 57,141.0 сая төгрөгөөр буюу 4,631.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

2.1.2 Орон нутгийн 2024 оны төсвийн төсөл өмнөх онуудаас дараах онцлогтой боловсруулагдсан байна. Үүнд:



- Хөдөөгийн суманд ажиллаж байгаа төрийн захиргаа, төрийн тусгай албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийг 40 хувь, аймгийн төвд ажиллаж байгаа албан хаагчдад 20 хувиар тус тус тооцож олгохоор төсвийн суурь зарлагад тусгасан. Үүнээс гадна босоо бүтэцтэй байгууллагын төрийн захиргааны албан хаагчдад 1,371.9 сая төгрөгийн орон нутгийн нэмэгдэл олгохоор,
- Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3⁷-д заалтын дагуу сумын ИТХ болон ЗДТГ-т ажиллаж байгаа Төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутамд 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулалд 637.8 сая, аймгийн төвд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутамд 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулалд 839.1 сая төгрөг тус тус олгохоор,
- 2024 онд төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэхээр тооцсон байна.
- Орон нутгийн хэрэгжүүлэх чиг үүрэгт боловсрол, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын зардлыг тусгасан зэрэг онцлог арга хэмжээнүүдийг тусгажээ.


2.1.3 Төсвийн төсөлд 2024 оны цалингийн зардлыг 22,604.4 сая төгрөгөөр батлахаар тусгасан нь өмнөх оноос 73.8 хувиар буюу 9,594.2 сая төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын үндсэн цалинг тайлант онд 10-20 хувиар, мөн босоо бүтэцтэй төсөвт байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл 1,371.9 сая төгрөгийн олгохоор тусгасантай холбоотойгоор өссөн байна.

График №4

⁷ Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.



2024 оны орон нутгийн төсвийн төсөлд 796 орон тоогоор тусган өмнөх оноос 42 орон тоогоор нэмэгдүүлсэн нь Орон нутгийн өмчийн газарт тайлант онд бүтцийн өөрчлөлт хийгдэхээр, аймаг, сумдын ЗДТГ-ын орон тоог нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна.



2.1.4 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг

2024 онд 16,646.5 сая төгрөгөөр буюу өмнөх оноос 28.6 хувиар буюу 3,697.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь БОЭТ, Булган сумын Нэгдсэн эмнэлэг, аймгийн төвийн 5, Булган сумын Өрхийн эрүүл мэндийн төв, Буянт сумын төсөвт байгууллагууд нэгдсэн халаалтын системд холбогдсон, мөн үнэ тарифт өөрчлөлт орсон зэргээс шалтгаалан нэмэгдүүлэн төсөвлөсөн байна.

Дулаан нийлүүлэх гэрээнд барилга байгууламжийн хувийн хэрэг, зураг төсөвт тусгасан эзлэхүүнээс илүү тооцон Хөгжил политехник коллежийн хичээлийн шинэ байрны, Жаргалант сумын 7-р цэцэрлэг, 4 дүгээр цэцэрлэгийн барилгын эзлэхүүнийг 2022 оны гэрээнд илүү тусгаж 49.6 сая төгрөгийн дулааны төлбөрийг илүү төлсөн нь Аж ахуйн харилцааны дүрмийн 5.1.1⁸ дэх, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөөгүй байна.

Хүснэгт - №3

д/д	байгууллагын нэр	илүү тусгасан хэмжээ /м3/	тариф	халаалтаар хангах сар	мөнгөн дүн /сая.төгрөг/
1	Хөгжил политехник коллежийн шинэ барилга	1,572.4	1,485	8	18.7
2	Жаргалант сумын 7-р цэцэрлэгийн 2 дугаар байр	1,945.5	1,485	8	23.1
3	Жаргалант сумын 11 дүгээр цэцэрлэгийн барилга	438.8	1,485	8	5.2
4	Жаргалант сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилга	219.9	1,485	8	2.6
НИЙТ ДҮН					49.6

2.1.6 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийн зардалд хүүхдийн эрх 20.0 сая, ХБИ 31.6 сая, мөрийн хөтөлбөр 300.0 сая, цэрэг татлагын үйл ажиллагаанд 60.0 сая, техник хяналтын зардалд 300.0 сая, нийт 711.6 сая төгрөг, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал агаарын бохирлыг бууруулахад 1,068.2 сая, аюултай хог хаягдлыг зайлуулахад 76.5 сая төгрөгийг зарцуулахаар тусгасан нь хэдэн төрлийн ажил,

⁸ Дулааны эрчим хүчээр хангах гэрээнд тусгагдсан дулааны тоолуур, усны тоолуурын заалт, барилгын эзлэхүүн, талбай, зураг төслийн тооцоот хүчин чадал, хүний тоо нь дулааны эрчим хүчний төлбөр тооцооны үндэслэл болно.



арга хэмжээг хэрэгжүүлэх нь тодорхой бус, нотлох баримтаар баталгаажуулах боломжгүй, холбогдох шатны байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийг үндэслэсэн зардлыг Засаг дарга данс буюу ангилагдаагүй зардалд төлөвлөсөн байна.

Хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний зардлын задаргааг холбогдох хууль, журамд нийцүүлэн боловсруулсныг нотлох боломжгүй байна.

2.2.1 Урсгал зардлын хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу дэд дарга, албан томилолт, дүрэмт хувцас, нэг удаагийн тэтгэмж, гар утасны зардал, бусад хангамжтай холбоотой зардлын хязгаарлалтуудыг баримтлан төсөвлөсөн байна.

2.2.2 Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4⁹, 31.1.6¹⁰, 31.4¹¹, 31.4.3¹² дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 тоот тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.1¹³, 7.6¹⁴, 7.7¹⁵ дэх хэсэгт заасны дагуу 2024 оны орон нутгийн төсвийн төсөлд тусгасан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалт, холбогдох нотлох баримтуудыг аудитыг гүйцэтгэх хугацаанд ирүүлээгүй нь Төсвийн тухай хууль, ОНХС-гийн журам заавартай нийцэхгүй байна. Үүнд:

- ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөсөн жагсаалтыг нотлох баримтын хамт аудитын хугацаанд ирүүлээгүй
- ОНХС-ийн хөрөнгө оруулалтад дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийг байгаль орчин, газрын харилцаа, хөдөө аж ахуй, санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан ажилтан, холбогдох хэлтсийн албан тушаалтнууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулсан 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулах заалтын хэрэгжилт хангагдаагүй,
- Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг ОНХС-ийн УМС-ийн маягтын дагуу хэвлэж жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн жагсаалтгүй,
- Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн нэгдсэн жагсаалт, хурлын тэмдэглэл ирүүлээгүй,
- "Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх хэсэгт "аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх" гэж заасны дагуу орон нутгийн 2024 оны төсвийн төслийг аймгийн Засаг дарга Төрийн аудитын байгууллагад иж бүрэн ирүүлээгүй,

⁹ эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;

¹⁰ худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх.

¹¹ Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана:

¹² шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тооцоо;

¹³ Аймаг, нийслэлийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийг байгаль орчин, газрын харилцаа, хөдөө аж ахуй, санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан ажилтан, холбогдох хэлтсийн албан тушаалтнууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулсан 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна"

¹⁴ Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг ОНХС-ийн УМС-ийн маягтын дагуу хэвлэж жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

¹⁵ Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн нэгдсэн жагсаалтыг хурлын тэмдэглэл болон орон нутгийн төсвийн төсөлд тусган аймаг, нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.



- ОНХО, ОНХС, их засвар, Замын сан, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны санхүүжилтээр хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний жагсаалтуудыг ирүүлээгүй,
- Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах доорх шаардлагуудыг хангасан эсэх талаар баримт ирүүлээгүй. Үүнд:
 - Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна;
 - Тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;
 - Барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;
 - Техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх;
 - Урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх;

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д “Төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах ... мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах” гэж заасны дагуу Ховд аймгийн ТЕЗ-ын 2024 оны төсвийн төсөлтэй холбоотой нотлох баримтыг ирүүлэхийг Аймгийн Засаг даргад 2023 оны 9 дүгээр сарын 18-ний өдрийн 234 тоот албан бичгээр мэдэгдсэн ч ХБТХОХ-ээс 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын жагсаалт, холбогдох баримтууд ирүүлээгүй болно.

2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын жагсаалт, холбогдох нотлох баримтыг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй нь Төрийн аудитын стандарт 6817-6:2020-ын 6.4 нийцлийн аудитын баталгаажуулалт хэсгийн 6.4.2-т “...хязгаарлагдмал баталгаажуулалт нь шалгасан зүйлийг холбогдох шалгуур үзүүлэлтэд нийцээгүй гэх үндэслэл аудиторын анхааралд өртсөн эсэх талаар мэдээлнэ.” гэж заасны дагуу хөрөнгө оруулалтын зардлыг баталгаажуулах боломжгүй нөхцөл үүссэн тул хязгаарлагдмал¹⁶ дүгнэлт гарган хүргүүлж байна.

БҮЛЭГ 3. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН УРСГАЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТИЙН ҮР АШИГ, ХҮРЭХ ҮР ДҮНГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ЗАРДЛЫГ АНГИЛАН ТӨЛӨВЛӨСӨН Ч ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНГ ТООЦОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА

Төсвийн төсөлд 27 хөтөлбөрийн хүрээнд 33 арга хэмжээг төлөвлөжээ

3.1.1 Урсгал зардлыг төлөвлөхдөө Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан төлөвлөжээ.

3.1.2 Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2-т “хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх;” 31.4.6-д “төсвийг хэрэгжүүлэхэд шаардагдах орц, төсөв, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх үр дүнг хөтөлбөрөөр болон эдийн засгийн ангиллаар илэрхийлсэн зарлагын хуваарилалтын тооцоо;” гэсэн заалтын дагуу ТЕЗ-ийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлттэй холбоотой бичиг баримтуудыг ирүүлээгүйгээс бодитой төлөвлөсөн нь тодорхой бус байна.

¹⁶ Төрийн аудитын стандарт 6817-6:2020-ын 6.4 нийцлийн аудитын баталгаажуулалт хэсгийн 6.4.2-т “...хязгаарлагдмал баталгаажуулалт нь шалгасан зүйлийг холбогдох шалгуур үзүүлэлтэд нийцээгүй гэх үндэслэл аудиторын анхааралд өртсөн эсэх талаар мэдээлнэ.”



Аймгийн ИТХ-аас ТЕЗ-ийн 2023 онд хэрэгжүүлэх 22 хөтөлбөр, 33 арга хэмжээнд нийт 82,510.4 сая төгрөгийг зарцуулахаар батлагдаж, 2024 онд 27 хөтөлбөр, 33 арга хэмжээнд 91,194.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

3.1.3 Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэж заасны дагуу орон нутгийн 2024 оны төсвийн төслийг Сангийн ямаар хянуулахаар хүргүүлсэн төсөвт өрийн бичиг, бонд, зээлтэй холбоотой авлага, өглөг үүсгээгүй нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.1.4 2024 онд байр ашиглахтай холбоотой зардлыг өмнөх оноос 3,709.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь халаалтын тариф 30 хувиар өссөн, улсын төсвийн байгууллагуудын халаалтын зардлыг орон нутгийн төсөвт тусгасан зэрэгтэй холбоотой байна.

Тогтмол зардалтай холбоотой дотуур байрны халаалтын зардлыг 2024 онд сумдын сургуулиудын дотуур байрыг барилгын талбайн хэмжээг Эрчим хүчний салбарт мөрдөгдөж буй аж ахуйн харилцааны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3.1¹⁷, 5.3.4¹⁸-д заасны дагуу айл өрхийн тарифаар тооцон 397.5 сая төгрөгөөр хэмнэхээр төлөвлөжээ.

Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2018 оны 292 тоот тогтоолоор шинэчлэн баталсан дүрмийн 5.3.1¹⁹, 5.3.4²⁰ дэх заалтын дагуу төсөвт байгууллагуудын халаах талбайг бодитой хэмжсэнээр түлш халаалтын зардлыг хэмнэх боломжтой байна.

ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАГДААГҮЙ БАЙНА

1.Төрийн аудитын байгууллага Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

2. Энэ нь өмнөх аудитын үр нөлөөг батжуулж, дараагийн аудитын чанар, үр нөлөөг сайжруулах нөхцөл болох бөгөөд аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилтот хэрэглэгчийг өмнө хийсэн аудитын тайлан болон тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн санах, дүгнэх боломж олгодог чухал ач холбогдолтой аудитын нэг үе шат юм.

3. Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгсөн аудитаар аймгийн ИТХ-д 6, аймгийн Засаг даргад 3, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт 3 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжилт хангагдаагүй байна.

¹⁰ Аливаа барилга байгууламж, орон сууц нь дулааны тоолуур суурилагдаагүй бол дулааны эрчим хүчний төлбөр тооцоог энэхүү дүрэмд заасны дагуу эзлэхүүн болон талбайн хэмжигдэхүүнээр гэрээний дагуу тооцно. Орон сууцны барилгыг ахуйн зориулалтаар нь ашиглаж, хүн амьдарч байгаа бол талбайн хэмжигдэхүүнээр, үүнээс бусад нөхцөлд эзлэхүүнээр тооцно

¹⁸ Аж ахуйн үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдсан барилгад, дулааны тоолуур суурилуулах боломжгүй тохиолдолд халаалтын төлбөрийг эзлэхүүнээр тооцно. Тухайн барилгын халаалтын төлбөр тооцох эзлэхүүнийг өрөөний урт, өргөн, өндөр/давхрын бодит өндөр/-ийн хэмжээгээр тодорхойлно. Анхны батлагдсан зургаас өөр зориулалтаар уг барилгыг ашиглах бол мэргэжлийн байгууллагын дүгнэлт, дулааны эрчим хүчээр найдвартай хангах техникийн хувьд боломжтой эсэх тооцоог үндэслэн эх үүсвэрийг тогтооно.

¹⁹ Аливаа барилга байгууламж, орон сууц нь дулааны тоолуур суурилагдаагүй бол дулааны эрчим хүчний төлбөр тооцоог энэхүү дүрэмд заасны дагуу эзлэхүүн болон талбайн хэмжигдэхүүнээр гэрээний дагуу тооцно”.

²⁰ “Аж ахуйн үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдсан барилгад, дулааны тоолуур суурилуулах боломжгүй тохиолдолд халаалтын төлбөрийг эзлэхүүнээр тооцно. Тухайн барилгын халаалтын төлбөр тооцох эзлэхүүнийг өрөөний урт, өргөн, өндөр/давхрын бодит өндөр/-ийн хэмжээгээр тодорхойлно”



Аудитаар Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4²¹, 31.1.6²², 31.4²³, 31.4.3²⁴ дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 тоот тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.1²⁵, 7.6²⁶, 7.7²⁷ дэх хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх хэсэгт заасан заалтуудыг хэрэгжүүлээгүй тул ХБХО-ын хэлтсийн дарга, мэргэжилтэн нарт хариуцлага тооцуулах албан шаардлага өгөхөөр санал хүргүүлсэн ч 11 дүгээр сард ЗДТГ-ын даргын А/121, А/123 тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Аудитаар төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхтэй холбоотой 4 зөвлөмж өглөө

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна.

- Үл хөдлөх эд хөрөнгийн татвар, хог хаягдлын хураамж, замын байгууламж ашигласны төлбөрийн орлогыг 425.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтыг хуульд заасан хугацаанд ирүүлээгүйгээс төлөвлөсөн арга хэмжээг хууль, журамд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.
- Төсөвт байгууллагуудын урсгал арга хэмжээний зардлын санхүүжилтийн үр ашиг, хүрэх үр дүнг хэрэгжүүлэх хөтөлбөр, зардлыг ангилан төлөвлөсөн ч хөрөнгө оруулалтын үр дүнг тооцох боломжгүй байна

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

1. БХС, ОНХС, ОНХО, Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29, 29¹ дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д тус тус заасан төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөн батлах

Аймгийн Засаг даргад

1. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасан хугацаанд төсвийн төслийг боловсруулан, өргөн барих

²¹ эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;

²² худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх.

²³ Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана:

²⁴ шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тооцоо;

²⁵ Аймаг, нийслэлийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийг байгаль орчин, газрын харилцаа, хөдөө аж ахуй, санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан ажилтан, холбогдох хэлтсийн албан тушаалтнууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулсан 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна”

²⁶ Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг ОНХС-ийн УМС-ийн маягтын дагуу хэвлэж жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

²⁷ Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн нэгдсэн жагсаалтыг хурлын тэмдэглэл болон орон нутгийн төсвийн төсөлд тусган аймаг, нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.



2. Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7-д “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг эрчим хүч, хэрэглээний цэвэр, бохир ус, дулаан, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөртэй хамтатган хураах замаар төвлөрүүлж болно” гэсэн заалтыг хэрэгжүүлэн айл өрхийн хог хаягдлын хураамжийг нэгдсэн байдлаар төвлөрүүлэх

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал д

1. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8 дахь хэсэгт заасны дагуу Булган сумын хог хаягдлын хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Төрийн аудитын газарт ирүүлэх

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР